БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2019 оны 04 дугаар сарын 04 өдөр

Дугаар 315/2019

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
факс: 976-11-320338

Объектын байршил, нэр:	Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “63-р цэцэрлэгийн барилга”-ын засварын зураг төсөл, төсөв **ШИФР: АГХ-18/69**
Хүчин чадал:	Тус барилгын А блок нь тэнхлэгээрээ 36.3 м х 12.0 м хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар, Б блок нь тэнхлэгээрээ 15.0 м х 6.0 м хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар
Захиалагч:	Нийслэлийн боловсролын газар
Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч:	“Алтайн газрын хүч” ХХК
Регистрийн дугаар:	РД: 4067622
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2021.06.07
Ажилбарын төрөл:	1.2.1, 1.2.4, 1.2.6, 1.3.1, 1.3.2, 1.2.5, 1.3.3 заалтын дагуу

Зураг төсөл боловсруулах үндэслэл:

Архитектур төлөвлөлтийн даалгавар, батлсан албан тушаалтан, дугаар, огноо:	“Эрчим хүчний үр ашиг” төслийн захирлын 2018 оны 08-р сарын 01-ний өдөр батлсан № 09/18 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгавар

Зөвшөөрөлцсөн байгууллагууд:

НОБГ-ын БЗТХ-ын ахлах байцаагч, Дэд хурандаа	Л.Тэгшбаяр
Нийслэлийн боловсролын газрын дарга	Ж.Гантулга

Зураг төслийн бүрэлдэхүүн:

Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Барилга архитектур:	“Алтайн газрын хүч” ХХК	Ц.Батбаяр
Халаалт агаар сэлгэлт:	“Алтайн газрын хүч” ХХК	Б.Бат-Эрдэнэ
Төсөв:	“Алтайн газрын хүч” ХХК	Л.Оюун

Ерөнхий дүгнэлт:/Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоол/

Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч	**Инженерийн байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:** Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “63-р цэцэрлэгийн барилга”-ын засварын ажлын зураг төсөл, төсвийг “Эрчим хүчний үр ашиг” төслийн захирлын 2018 оны 08-р сарын 01-ний өдөр батлсан № 09/18 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг үндэслэн боловсруулсан байна. Байгаль цаг уурын өгөгдөл: Гадна агаарын хэм: -38.4^{o}C Цасны ачаалал: 30 кг/м^{2}

тодорхойлолт:	Салхины ачаалал: 45 кг/м^2 Газар хөдлөлийн бичил мужлал: 8 балл **Засварын ажлын хүрээнд:** **Гадна засал:** Одоо байгаа бетон хаяавчийг 100% буулгаж гадна фасад болон суурийн хэсгийг дулаалсаны дараа барилгын эргэн тойронд 1 метр өргөнтэй бетон хаяавчийг шинээр хийхээр, гадна хаалга болон цонхыг 100% солихоор тус тус төлөвлөсөн байна. **Дотор засал:** 1-р давхрын 105, 106, 107 дугаартай өрөөг, 2-р давхрын 211, 212 дугаартай өрөөнүүдийн гадна ханыг дотор талаас нь дулаалсан байгаа бөгөөд уг хөөсөнцөр дулаалгыг бүрэн буулгаж ханыг засварлахаар төлөвлөсөн байна. **Дээвэр:** Дээврийн салхивчийн яндан эвдэрч нурсан хэсгийг засварлаж хуучин ус хаялаганы төмрийг буулгаж 100% шинээр хийхээр, дээврийн дулаалгыг хийхдээ хар цаасан дээвэр дээр С төмрийг байршуулан С төмөр хооронд 10 см зузаантай EPS хөөсөнцөр хавтан хийж 10 см зузаантай хучилтын сэндвичэн хавтан хавтангаар давхарлан хучиж зориулалтын бэхэлгээгээр бэхэлхээр зураг төслийг боловсруулсан байна. **Халаалт агаар сэлгэлт:** Тус барилгын халаалтын системийг дооpоос түгээлттэй 2 хоолойт мухардмал системтэй байхаар төлөвлөсөн байна. Мөн барилгын оролтоос оролтын узель хүртэлх сувагт байгаа дулаалгатай 2 Ф 76 мм-ийн голчтой хоолой, оролтын узелийн бүх тоног төхөөрөмжийг шинээр угсрахаар зураг төслийг боловсруулсан байна. Дулааны зарцуулалтын тооцоо: $Q_{бүгд}$=110.0 кВт, $Q_{хал}$=110.0 кВт
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт:	**Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг холбогдох орон тооны бус экспертүүд шалгаад:** Холбогдох норм дүрмийн дагуу боловсруулсан, экспертийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг засвар өөрчлөлтүүдийг хийсэн уг зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэж болно гэж дүгнэсэн байна.
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгын засвар хийгдсэнээр хүүхдүүд тав тухтай аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөл боломж бүрдэх юм.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 63-р цэцэрлэгийн барилгын засварын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоо	
1	а/. Засварын ажил /36.3 м х 12.0 м хэмжээтэй, зоорьгүй 2 давхар/:

1.1	Дээврийн засвар: хучилт 100 мм-ийн хөөсөнцөр хавтангаар дулаалах, 100 мм хөөсөнцөр хавтан дулаалгатай сэндвичэн хавтан налуу дээвэр хийх	86,466,613.0	637.2	135,697.76
1.2	Гадна заслын засвар: Гадна хана 150 мм хөөсөнцөр хавтангаар дулаалах, чулуун будаг хийх, цоколын хэсэгт ус тусгаарлагч хийж засал хийх	111,073,534.0	1,311.3	84,704.90
1.3	Ариун цэврийн өрөөний засвар: Ариун цэврийн өрөөний хана, таазны засвар, ариун цэврийн өрөөний тоноглол солих	6,442,282.0	175.7	36,666.37
1.4	Хаалга, цонхны засвар: 154.52 м2 цонх солих, 46.6 м2 гадна, дотор хаалга солих, хаалга, цонхны амалгааны засвар	79,558,383.0	201.1	395,616.03
1.5	Гадна төмөр шат: Бетон тулгууртай төмөр шат, 10.29 м урт, 1.0 м өргөнтэй	21,072,575.0	10.3	2,047,869.29
1.6	Дулааны узель: Дулаан тоолуур, тоног төхөөрөмжийн угсралт	4,437,240.0	1.0	4,437,240.00
1.7	Халаалтын шугамын засвар /м/: Халаалтын шугамын ган хоолой солих	18,515,082.0	330.0	56,106.31
Хэсгийндүн:		**327,565,709.0**	**1,051.2**	**311,611.2**
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:			**327,565,709**	

Төсөв: Эксперт нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах "63-р цэцэрлэгийн барилга"-ын засварын ажлын төсөвт өртгийг **327 565 709.0** (гурван зуун хорин долоон сая таван зуун жаран таван мянга долоон зуун ес) төгрөгөөр хянасан байна.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх'', 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх'', 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Тухайн зураг төсөл нь Нийслэлийн Онцгой байдлын газрын Барилгын зураг төслийн хяналтын байцаагчийн 2019.02.01-ний өдрийн № 009/27 дугаартай дүгнэлтээр хянагдсан байна.

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах "63-р цэцэрлэгийн барилга"-ын засварын ажлын зураг төсөлд "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн **3** хуудас магадлалын хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.АМАРСАНАА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.САРАНТУЯА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ЗОЛБОО